

**ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Гүйцэтгэсэн: Н.Норовсамбуу /МУИС, Хууль зүйн сургуулийн багш/

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох тандан судалгаа

I. Удиртгал

II. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгцээ, шаардлага

3.1. Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх

3.2. Гэр бүлийн хэрэг

3.3. Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх онцлог зохицуулалт

III. Өсвөр насны хүний үйлдсэн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох

IV. Дүгнэлт

I. Удиртгал

Энэхүү судалгааны зорилго нь Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх байгуулагдсантай холбогдуулан гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өргөн хүрээнд тодорхойлон Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн төслийн хэрэгцээ, шаардлага бий эсэхийг тандан судлахад оршино.

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалтад Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн 1 дэх заалтад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг тус тус байгуулахаар заасан.¹

Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд тус зохицуулалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.²

Түүнчлэн, “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоолын 4-т нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн болон давж заалдах шатны шүүх байгуулсантай холбогдуулан эрүү, иргэний хэргийг хянан шийдвэрлэх хууль тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэхийг даалгасан.

II. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгцээ, шаардлага

1/Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх

Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалтад Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, 2 дугаар зүйлийн Дөрөв

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721145671>

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721217671>

дэх хэсгийн 1 дэх заалтад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг тус тус байгуулахаар болсон.

Олон улсын туршлагаас үзвэл, 1949 онд Япон Улсад байгуулагдсан гэр бүлийн хэргийн дагнасан шүүх нь Азийн хамгийн анхны гэр бүлийн хэргийн дагнасан шүүх болж байгуулагдаж байсан бөгөөд Personal Status Litigation Act буюу Гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх хуулиар гэр бүлийн хэрэгт тохирсон онцлог процесс ажиллагааг нь зохицуулдаг байна.³

Түүнчлэн Бүгд найрамдах Солонгос улс /БНСУ/-д 1963 онд Сөүл хотын гэр бүлийн хэргийн дагнасан шүүх байгуулагдсан нь Япон Улсын дараа орох анхны гэр бүлийн дагнасан шүүх болно. Тус шүүх нь Family Litigation Act буюу Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх бие даасан хуульд гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх онцлог зохицуулалтыг бий болгосон.

Иймээс дагнасан шүүхтэй бол бие даасан тусдаа хуультай байх нийтлэг жишгийг баримтлан Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага бий болов.

2/Гэр бүлийн хэрэг

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар бүлэг буюу Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаагаар гэрлэлт цуцлуулах тухай иргэний хэргийг шийдвэрлэж байна.

Мөн тус хуулийн 13 дугаар бүлэг буюу Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаагаар зарим гэр бүлийн холбогдолтой байж болох хэргүүдийг шийдвэрлэж байна. Үүнд:

Хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах, сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох, садан, төрлийн холбоо, бусдын асрамжинд байгаа эсэхийг тогтоох, хүүхдийн эцэг, эхийг тогтоох, хүүхдээ тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад болон асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх зэрэг.

Эдгээр нь family case буюу гэр бүлийн хэрэг гэсэн нэр томъёонд хамаарч байгаа юм.

Олон улсын туршлагаас үзвэл, 1949 онд Япон Улсад байгуулагдсан гэр бүлийн хэргийн дагнасан шүүх нь Азийн хамгийн анхны гэр бүлийн хэргийн дагнасан шүүх болж байгуулагдаж байсан бөгөөд Personal Status Litigation Act буюу Гэр бүлийн

³ <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4178/en>

хэргийг хянан шийдвэрлэх хуулиар гэр бүлийн хэрэгт тохирсон онцлог процесс ажиллагааг нь зохицуулдаг байна.⁴

Түүнчлэн Бүгд найрамдах Солонгос улс /БНСУ/-д 1963 онд Сөүл хотын гэр бүлийн хэргийн дагнасан шүүх байгуулагдсан нь Япон Улсын дараа орох анхны гэр бүлийн дагнасан шүүх болно. Тус шүүх нь Family Litigation Act буюу Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх бие даасан хуульд гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх онцлог зохицуулалтыг бий болгосон.

Ийнхүү гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог зохицуулалтыг гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх бие даасан хуульд тусгасан байх ба уг хуульд зохицуулаагүй харилцааг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх процессын хуулиар зохицуулдаг байдал нийтлэг ажиглагдаж байна.⁵

Дээрх улсуудын гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиудад “гэр бүлийн хэрэг” гэдэгт гэрлэлт цуцлалт, түүнтэй холбоотой хүүхдийн тэтгэлэг гаргуулах, хүүхдийн асрамжийг хэнд үлдээх, дундын эд хөрөнгийг хуваах зэрэг хэргээс гадна үрчлэлт, асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоох, хүчингүй болгох, хүүхдийн эцэг, эхийг тогтоох, гэрлэлт хүчин төгөлдөр бусад тооцох, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бусад тооцох зэрэг олон төрлийн хэргийг хамруулдаг байна.⁶

Мөн БНСУ-ын хувьд litigious cases буюу мэтгэлцээн бүхий, non-litigious cases буюу мэтгэлцээнгүй хэрэг гэж нийт харьяаллын хэргийг 2 ангилж, 5 дэд хэсэг (A-E)-т хувааж жагсаасан. Өөрөөр хэлбэл, мэтгэлцээнтэй хэрэг, мэтгэлцээнгүй хэрэгт ялгамжтай процессын журам хэрэглэгддэг бөгөөд мэтгэлцээнтэй хэрэгт иргэний процессын хуулийн зохицуулалт, мэтгэлцээнгүй хэргийг Non-Contentious Case Procedure Act буюу Мэтгэлцээнгүй хэргийг шийдвэрлэх процессын хуулийг хэрэглэдэг байна.

В, С, Е ангиллын хэргүүд нь conciliation-precondition principle зарчим хэрэгждэг буюу эвлэрүүлэн зуучлалаар заавал орох гэрлэлт цуцлалт, түүнтэй холбоотой хүүхдийн асрамж, тэтгэлэг, дундын эд хөрөнгө хуваах, хамтын амьдрал байсан эсэхийг тогтоох, гэрлэлт цуцлалтын улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг хэргүүд болно.

Харин А, D ангиллын хэрэг болох гэрлэлт, гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцох, сураггүй алга болсонд тооцох, сураггүй алга болсонд тооцсоныг хүчингүйд тооцох, овог нэр тогтоох, үрчлэлт, асран хамгаалалт, харгалзан дэмжлэг, гэрлэлтийн гэрээнд өөрчлөлт оруулах, өв гэрээслэл зэрэг нь эвлэрүүлэн зуучлал шаардлагагүй буюу эвлэрүүлэн зуучлалын бус хэрэг байдаг.

Иймд хуулийн төслөөр “гэр бүлийн хэрэг”-ийн төрлийг өргөжүүлж, ангилан, эвлэрүүлэн зуучлалаар заавал орох хэргийг тодорхойлж, тэдгээрийн онцлогт нь

⁴ <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4178/en>

⁵ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=1081&lang=ENG

⁶ Personal Status Litigation Act Japan 2003, 2 дугаар зүйл. Family Litigation Act 2007, 2 дугаар зүйл.

тохирсон процессыг уг анхдагч хуулийн төсөлд тусган, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага үүсчээ.

3/Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч, шүүх өөрөө нотлох зарчим /fact finding/

Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд диспозитив зарчмаас гадна хүүхдийн хууль ёсны дээд эрх, ашиг сонирхол /best interest of the child/-ыг тэргүүн ээлүид хамгаалах зорилгоор гэр бүлийн нөхцөл байдлыг нарийн шалган тогтоох /fact finding/ ажиллагаа хийгддэг.

Тодруулбал, Япон, БНСУ зэрэг гэр бүлийн дагнасан шүүхтэй улсуудад, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүгч өөрийн санаачилгаар захирамж гарган гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч /family investigator/-ээр гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлуулж, үнэлгээний тайлан гаргуулах, ач холбогдол бүхий бусад шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах зэрэг бүрэн эрхтэй байдаг.

Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч гэр бүлийн нөхцөл байдлыг нягтлан шалгаж, маргааны шалтгаан нөхцөлийг тогтоож, эвлэрэх боломжтой эсэх, боломжтой бол эвлэрэх арга замыг санал болгох зэргээр шүүгч шийдвэрээ гаргахад шаардлагатай нөхцөл байдлыг тал талаас нь судална.

Энэхүү гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч нь шүүхийн ажилтан байх бөгөөд аль ч талд орохгүй, хараат бусаар, асуудлыг тал бүрээс нь судлах үүрэгтэй бөгөөд хуульч бус, нийгмийн ухаан, сэтгэл зүй, боловсрол зэрэг чиглэлийн магистрын зэрэгтэй байх шаардлага тавигддаг.⁷

БНСУ-ын хувьд, А, В ангиллын хэрэгт буюу гэрлэлт цуцлалт, гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бусад тооцох, үрчлэлт зэрэг зарим хэрэгт гэр бүлийн шүүхийн шүүгч шинжлэн судлах ажиллагаа /ex officio fact finding/ явуулдаг буюу гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судалсан үнэлгээг шийдвэр гаргахдаа харгалзан үздэг.⁸

Холбооны Бүгд найрамдах Герман улс /ХБНГУ/-д шүүх гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэхдээ гэр бүлийн нөхцөл байдлыг тогтоох зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зарим шаардлагатай шинжлэн судлах ажиллагааг мөн явуулдаг.⁹

Манай улсын хувьд энэ талаарх зохицуулалт хуульд байхгүй ч Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан нөхцөл байдлын үнэлгээг хийлгэж, гэрлэлт цуцлахад нотлох баримтаар авч үзэж байгаа практик байна.

⁷ IDLO зөвлөх Hyoun-g-ryul, KIMPresiding Judge, Seoul Family Court-ийн хуулийн төсөл боловсруулахад өгсөн зөвлөмж 2025.

⁸ IDLO зөвлөх Hyoun-g-ryul, KIMPresiding Judge, Seoul Family Court-ийн хуулийн төсөл боловсруулахад өгсөн зөвлөмж 2025.

⁹ ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн 125 дугаар зүйл.

Хуулийн төслөөр шүүгч тодорхой хэрэгт, тухайлбал хүүхдийн дээд эрх, ашиг сонирхолыг хангах үүднээс гэрлэлт цуцлахад хүүхдийг хэний асрамжид үлдээх асуудлыг шийдвэрлэхэд зөвхөн талуудын нотлох баримтад тулгуурлах бус өөрийн санаачилгаар гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлах /fact finding/ ажиллагаа явуулах процесс, системийг бий болгох шаардлагатай байна.

III. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага

Өсвөр насны шүүгдэгчийн үйлдсэн хэргийг шийдвэрлэхдээ хаалттай, эсхүл нээлттэй шийдвэрлэж болохоор одоогийн Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгасан байгаа болно. Тэгвэл гадаад улсын туршлагаар нээлттэй байдлыг зөвшөөрдөг эсэх талаар судлан үзэхэд:

Япон Улс

Шүүх хуралдааныг явуулахдаа эелдэг зөөлөн уур амьсгалыг бүрдүүлж, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхдийг өөрийн буруу зан үйлийн талаар эргэцүүлэн бодоход түлхэц өгөх ёстой.¹⁰ Шүүх хуралдааныг хаалттай явуулна.¹¹

БНСУ

Шүүх хурлыг өсвөр насны хүүхдийн ирээдүйн төлөө хаалттай явуулах¹² бөгөөд мөн тухайн хүүхдийн хувийн мэдээлэл бүхий мэдээллийг тараахыг хуулиар хориглодог байна.¹³

Өсвөр насны хүүхдийг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны чиг үүргээ биелүүлэхэд бүхий л захиргааны байгууллага, сургууль, эмнэлэг зэрэг нийгмийн бүхий салбарыг хамран хамтран ажиллах шаардлагатай.¹⁴

Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг үнэлэх, бодит нөхцөл байдлыг тогтоох зорилгоор анагаах ухаан, сэтгэл судлал, боловсрол судлал болон бусад салбарын мэргэжлийн дүгнэлтийг ашиглах ёстой байдаг.¹⁵

¹⁰ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

¹¹ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

¹² БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дүгнэлт. 헌법재판소 2012.7.26. 선고 2011헌마232 결정.

¹³ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 68 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

¹⁴ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 28 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

¹⁵ БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дүгнэлт. 헌법재판소 2012.7.26. 선고 2011헌마232 결정.

Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийг хяналтад байлгах таслан сэргийлэх арга хэмжээний тухайд:

Монгол Улсын нэгд орсон Хүүхдийн эрхийн конвенцын¹⁶ 37 дугаар зүйлийн (а)-д “хүүхдийн эрх чөлөөг хууль бусаар буюу дур мэдэн хязгаарлаж болохгүй. Хүүхдийг баривчлах, саатуулах, хорих арга хэмжээг хамгийн богино тохиромжтой хугацаанд эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх” гэж заасан байдаг ч өсвөр насны сэжигтэн яллагдагч, шүүгдэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээ тодорхойгүй, өсвөр насны хүнд хэрэглэхэд тохиромжгүй байсан.

Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон бусад итгэмжлэгдсэн этгээдийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн тэднийг шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсан цагт ирүүлж байхыг хариуцаж хяналтад байлгах баталгааг авах таслан сэргийлэх арга хэмжээг бий болгох шаардлагатай байна.

Уг таслан сэргийлэх арга хэмжээ нь цагдан хорих таслан сэргийлэх хэмжээг хэрэглэхгүй байх, бууруулахад ач холбогдолтой. Тухайлбал, Бүгд Найрамдах Казакстан Улсын эрүүгийн процессын хуульд “Насанд хүрээгүй хүүхдийг хяналтад өгөх таслан сэргийлэх арга”¹⁷ хэмжээг тусгасан байна.

Өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх нийтлэг зохицуулалтын тухайд:

Олон улсын жишигт, тодруулбал Хүүхдийн эрхийн тухай конвенц, Дэлхийн эрүүгийн процессын загвар хуульд¹⁸ өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувийн мэдээллийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нууцлах зохицуулалтыг өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлага гэж хуульчилсан байсныг эрүүгийн процессын ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлага болгон өөрчлөх шаардлагатай.

Мөн өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцуулах боломжгүй, эсхүл тийм хүн байхгүй тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр томилон оролцуулах, шаардлагатай тохиолдолд өсвөр насны хүнээс мэдүүлэг авахад сэтгэлзүйчийг оролцуулах зэрэг онцлог зохицуулалт бусад улсад нийтлэг байгааг авч, хуулийг боловсронгуй болгох шаардлагатай.

Өсвөр насны хүний үйлдсэн хэрэгт хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах:

Ихэнхи улсуудад өсвөр насны хүний үйлдсэн хэргийг хянан шийдвэрлэх тусгай процесс ажиллагааны журам байх бөгөөд ХБНГУ, АНУ-ын Хавай мужийн хуулиудад хүүхдийг аль болох хүмүүжүүлэх, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг түлхүү хэрэглэдэг байна.

¹⁶ Монгол Улсын олон улсын гэрээ Хүүхдийн эрхийн тухай конвенц - <https://legalinfo.mn/mn/detail/1276>

¹⁷ УПК РК. Статья 144. Отдача несовершеннолетнего под присмотр

¹⁸ Model Code of Criminal Procedure. Vivienne O'Connor and Colette Raush editors, Pease building and Rule of law. W. 2008.

Тухайлбал, эдгээр улсын хуулиудад өсвөр насны хүнд болон түүний гэр бүлд сэтгэл зүйчээс зөвөлгөө, эмчилгээ авахыг даалгах, нийгэмд тустай ажил хийлгүүлэх, нийгэмд чиглэсэн сайн дурын ажиллагаанд хамруулах, хичээлийн ирцээ тогтмол хүргүүлэхийг даалгах, хохирогчоос уучлал хүсэхийг даалгах, шөнийн цагаар гэртээ байхыг даалгах зэрэг арга хэмжээг өсвөр насны хүнд тусгайлан авч байна.

ДҮГНЭЛТ

Гэр бүлийн хэргийн дагнасан шүүхтэй улсуудад бие даасан Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар онцлог зохицуулалтыг бий болгож байгаа бөгөөд гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх зарчмаас гадна fact finding буюу шүүх нотлох, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн тал бүрээс нь судлах, хүүхдийн эрх, ашгийг тэргүүн ээлжид хамгаалах зарчим үйлчилж байх тул бие даасан тусдаа хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг нөхцөлдүүлж байна.

ЭХ СУРВАЛЖ

Шүүх байгуулах тухай хууль

Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Гэр бүлийн тухай хууль

Улсын дээд шүүхийн 2010 оны ИХШХШ ажиллагаан дахь зохигчдыг эвлэрүүлэх шүүгчийн ажиллагааны тухай 02 зөвлөмж

“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоол

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Судалгааны тайлангийн эмхэтгэл IX боть, 2022 он, Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа (Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ

Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг ТББ, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа, 2020.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Судалгааны тайлангийн эмхэтгэл IX боть, 2022 он, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүн шинжилгээ.

Б.Дугармаа, Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2019 он, №4.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудас 2024.11 сар.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны албан бичгээр ирүүлсэн статистик тоо мэдээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс албан бичгээр ирүүлсэн шүүхийн статистик мэдээ 2018-2023 он.

Shuukh.mn

БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг шийдвэрлэх тухай хууль
https://elaw.klri.re.kr/eng_service/lawViewContent.do?hseq=18173

БНСУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249995&efYd=20231019#0000>

БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дүгнэлт. 헌법재판소 2012.7.26. 선고 2011헌마232 결정.

Японы Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль.

ХБНГУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.

Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хууль

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хууль

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>